

**АНУ-ЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ХУУЛЬ, ҮНИЙН ЯЛГАВАРЛАЛТАЙ ХОЛБООТОЙ  
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**  
(Мэдээлэл лавлагаа)

*Ц.Болормаа, Д.Халиун, Р.Нургүл*

**АГУУЛГА**

- АНУ-ын “Монополийн эсрэг Шерманы хууль” болон Үнийн ялгаварлалын тухай хууль буюу Клейтоны хууль батлагдах болсон товч түүх буюу шалтгаан
- Шерманы хуулийн зохицуулалт
- Робинсон-Патманы тухай хуулийн зохицуулалт буюу Үнийн ялгаварлал
- Гадаад зарим орны туршлага
  1. Европын холбоо
  2. ОХУ
  3. БНХАУ
  4. Канад
  5. ИБУИНВУ

**Судалгааны хураангуй**

Хамрах хүрээ: Судалгаанд АНУ-ын Монополийн эсрэг Шерманы хууль батлагдах болсон товч түүх, тус хуулийн зохицуулж буй харилцааны талаар мэдээлэл бэлтгэв. Түүнчлэн ОХУ, БНХАУ, Канад, ИБУИНВУ зэрэг улсуудын өрсөлдөөний эрх зүйн ерөнхий зохицуулалт, үнийн ялгаварлал болон үнийг хэлцэн тогтоохтой холбоотой зүйл заалтын талаарх мэдээллийг хамруулав.

**АНУ-ын “Монополийн эсрэг Шерманы хууль” болон Үнийн ялгаварлалын тухай хууль буюу Клейтоны хуулийн зарим зохицуулалт**

- Энэ хууль батлагдах болсон товч түүх буюу шалтгаан
- Шерманы хуулийн зохицуулалт
- Робинсон-Патманы тухай хуулийн зохицуулалт буюу Үнийн ялгаварлал

*АНУ-ын монополийн хууль батлагдах болсон шалтгаан, товч түүх*

“Эдийн засгийн эрх чөлөөний иж бүрэн дүрэм, Худалдааны дүрмийн дагуу чөлөөтэй, саадгүй өрсөлдөөнийг хадгалах зорилго”-оор 1980 онд анхны Монополийн эсрэг хуулийг АНУ-ын Конгресс баталсан бөгөөд Сенатор Жон Шерманы нэрээр “Sherman Act” хэмээн нэрлэсэн байдаг.

Түүх дурдвал, АНУ-ын хэд хэдэн муж Шерманы хуультай төсөөтэй хууль баталсан боловч тэдгээр хууль нь мужийн доторх бизнесийн үйл ажиллагааг хязгаарлаж байжээ. Иймд Монополийн эсрэг Шерманы хуулийг муж хоорондын арилжааг зохицуулах Конгрессын Үндсэн хуулийн эрх мэдэлд тулгуурлан гаргасан гэж хуульч, судлаачид үздэг байна. Үүнийг Үндсэн хууль болон Муж Хоорондын Арилжааны тухай хуулиас илүү дэлгэрүүлэн харж болно.

Ийнхүү тус хуулийг 1890 оны 4 дүгээр сарын 8-нд парламентын доод Танхим 242-0 буюу санал нэгтгэйгээр, 6 дугаар сарын 20-нд Сенат 51-1 саналаар тус тус баталсан байдаг байна.

Шерманы хууль батлагдсанаар Холбооны Засгийн газар өрсөлдөөний журмуудыг хүчингүй болгох үйл ажиллагааг эхлүүлсэн байдаг. Түүнчлэн, “Эсрэг тэсрэг нөхцөл дахь

худалдаа, эсхүл хэд хэдэн муж хоорондын худалдаа, эсхүл гадаад улстай хийх худалдааг хязгаарлах зэрэг өрсөлдөөний хэлбэр"-ийг болон эдгээрийн аливаа хослолыг хууль бус гэж зарласан юм. Эдгээрийг үйлдсэн аливаа этгээдийг 5000 ам.долларын торгууль болон нэг жил хорих ялаар шийтгэж байсан байна.

1914 онд Конгресс монополийн эсрэг хоёр нэмэлт хууль баталсан нь "Холбооны худалдааны комиссын тухай хууль" болон "Үнийн ялгаварлалын тухай хууль" буюу "Клейтоны хууль"<sup>29</sup> юм. Хэдийгээр зарим нэмэлт орсон ч эдгээр гурван хууль нь Холбооны хэмжээнд өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж буй монополийн эсрэг гол хууль юм.

### **Клейтоны хууль**

Клейтоны хуулийг Монополийн эсрэг Шерманы хуульд заасан бизнесийн үйл ажиллагааг сайжруулах зорилго бүхий хууль юм.<sup>30</sup>

Тодруулбал, 1914 онд Шерманы хуульд заасан шударга бус өрсөлдөөний эсрэг хуулийн зохицуулалтыг улам сайжруулах, бэхжүүлэх зорилгоор Конгрессоос Клейтоны хуулийг баталсан байна. Энэ хуулиар уралдаант шалгаруулалт, шударга өрсөлдөөний эсрэг үнийн ялгаварлалыг хязгаарлах илүү дэлгэрэнгүй заалтуудыг хуульчилсан бөгөөд ингэснээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны орчин баталгаажих болон хувь хүн учирсан хохирлоо шүүхээр шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргах эрх нь онцгой баталгаатай болсон гэж үздэг байна. Мөн тус хуулиар шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх холбоо байгуулах эрхийг хуульчлан тогтоосон байна.

1912 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр гурван нам Конгрессоос 1890 онд баталсан Монополийн эсрэг Шерманы хууль шударга бус өрсөлдөөний харилцааг зохицуулахад хэтэрхий зөөлөн зохицуулалттай байна гэдэг дээр санал нэгдэж байжээ. Иймд Ардчилсан намаас ерөнхийлөгчид нэр дэвшигч Вүүд्रेү Вилсон (Woodrow Wilson) сонгуульд ялмагцаа Монополийн эсрэг хууль тогтоомжийг чангатгах хуулийн төсөл боловсруулахыг Конгресст даалгажээ. Ингэснээр 1914 онд одоо үйлчилж буй Клейтоны хуулийг нэмэлт хууль болгон баталсан байна. Шерманы хуулиар зохицуулаагүй шударга бус өрсөлдөөний эсрэг гол нэгэн гол зохицуулалт Клейтоны хуульд орсон нь аж ахуйн нэгжүүдийн "үнийн ялгаварлал" болон түүнийг хориглох тухай заалт байсан юм.

**Үнийн ялгаварлал:** Энэ нь хэтэрхий хүчтэй өрсөлдөөнийг бууруулах, эсвэл монополь байдал үүсгэж болох хэт шулсан зээлийн үйл ажиллагаанаас сэргийлэх байдлаар анх хийгджээ. Тухайлбал, хотуудын өөр хоорондоо адилгүй байдлаас хамааран өрсөлдөөн ихтэй хотод их үнэ, өрсөлдөөн багатай хотод бага үнээр худалдан борлуулах буюу үнээс хамаарсан өрсөлдөөнөөс болж аливаа аж ахуйн нэгжүүд нэг төрлийн бараа бүтээгдэхүүн дээр хоёр өөр үнийн стратегитай байж болохгүй гэж үзсэн юм. Энэхүү заалтыг 1960 он хүртэл өргөнөөр хэрэглэж байсан ч үнийн ялгаварлалыг зогсоохын тулд илүү хатуу стандарт боловсруулсан байна.

### **Робинсон-Патманы тухай хууль (1936)**

Робинсон-Патманы тухай 1936 оны хуулийг "Үнийн ялгаварлалын эсрэг хууль" гэж нэрлэх бөгөөд аж ахуйн нэгжүүдийг үнийн ялгаварлалтай холбоотой хууль бус үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх болон үнийн ялгаварлалыг хориглохын тулд батлагдсан хууль юм. Энэ хуулийн зохицуулалтын дагуу "**Үнийн ялгаварлал**" гэдэг нь ижил бараа, үйлчилгээг хоёр өөр хэрэглэгчдэд өөр өөр үнээр санал болгох үйл явц юм.

<sup>29</sup><http://www.law.cornell.edu/uscode/text/15/12>

<sup>30</sup><http://www.antitrustlaws.org/Clayton-Act.html>

Үнийн ялгаварлалын эсрэг хууль батлагдах үед, АНУ-ын Засгийн газар үнийн ялгаварлалыг өрсөлдөөний эсрэг практик гэж үзээд 1890 оны Шерманы Монополийн эсрэг хууль, 1914 оны Клейтоны Монополийн эсрэг хуулиар үнийн ялгаварлалыг таслан зогсоохыг оролдож байсан. Гэвч эдгээр нь төдий л амжилтад хүрэхгүй байсан тул үнийн ялгаварлалыг таслан зогсоохын тулд хатуу стандарт байх зайлшгүй шаардлагатай гэж үзсэнээр Робинсон-Патманы энэ хууль батлагдсан түүхтэй.

Үнийн ялгаварлалын тухай хууль буюу Робинсон-Патманы тухай хуулиар үнийн ялгаварлалыг бодитоор тогтоохын тулд заавал байх ёстой хэд хэдэн нөхцөлийг хуульчлан тогтоосон байна. Үүнд:

- (1) Гүйлгээ нь Муж хоорондын байх ёстой (cross state lines),
- (2) Нэг ижил борлуулагчаас хоёр өөр худалдан авагч авсан байх ёстой,
- (3) Ижил эсвэл эндүүрмээр адилхан бүтээгдэхүүн байх ёстой,
- (4) Ойролцоогоор нэг ижил цаг хугацаанд гарсан байх,
- (5) “Өрсөлдөөнийг багасгах, эсвэл Монополь үүсгэх”-д нөлөөлөх зорилгоор урьдаас бодож төлөвлөсөн байх ёстой.

Хэрэв үнийн ялгаварлал батлагдсан бол хариуцагч нь нэхэмжлэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээж, нэхэмжлэлийн шаардлагыг хангана.

Албан бус орчуулга

**Монополийн эсрэг Шерманы хууль**  
(The Sherman Antitrust Act, 1890)<sup>31</sup>

**1. Монополь болон хууль бус худалдааг хязгаарлах, ногдуулах шийтгэл.**

Муж хооронд эсвэл гадаад улстай хийх худалдаа арилжаанд саад хийх гэрээ байгуулах, монополь болон бусад хэлбэрээр нэгдэх эсвэл хуйвалдах нь хууль бус. Энд хууль бус гэж заасан аливаа гэрээ байгуулсан, эсвэл аливаа нэгдэл, хуйвалдаанд оролцсон этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх ба ял шийтгэл оноохдоо шүүхийн шийдвэрээр аж ахуйн нэгжид 10,000,000 ам.доллараас илүүгүй торгууль оноох, хувь хүнд 350,000 ам.доллараас илүүгүй торгууль оноох, эсвэл гурав хүртэл жилээр хорих болон дээрх шийтгэлийг давхардуулан ногдуулна.

**2. Худалдаа арилжаанд монополь байдал тогтоох гэмт хэрэг; ногдуулах шийтгэл.**

Муж хооронд эсвэл гадаад улстай хийх худалдаа арилжааны тодорхой хэсэгт монопольчлол тогтоосон эсвэл монопольчлохыг завдсан; эсвэл бусад этгээд болон этгээдүүдтэй нэгдсэн, хуйвалдан монопольчлол тогтоосон, эсвэл монопольчлохыг завдсан этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх ба ял шийтгэл оноохдоо шүүхийн шийдвэрээр аж ахуйн нэгжид 10,000,000 ам.доллараас илүүгүй торгууль ногдуулах, хувь хүнд 350,000 ам.доллараас илүүгүй торгууль ногдуулах, эсхүл гурав хүртэл жилээр хорих болон дээрх хоёр шийтгэлийг давхардуулан ногдуулна.

**3. Бус нутаг болон Колумб дүүрэг дахь хууль бус өрсөлдөөн, болон гэмт хэрэгт тооцогдох нэгдэл.**

Нэгдсэн Улсын эсвэл Колумб дүүргийн аливаа Бус нутагт худалдаа, наймаа хийхэд саад болох, эсвэл Бус нутаг хооронд, эсвэл Бус нутаг болон Муж улс (Муж улсууд), Колумб дүүрэг, гадны улс хооронд хийх худалдаа, наймаанд саад болох, эсвэл Колумб дүүрэг болон Муж улс (Муж улсууд), гадаад улстай хийх худалдаа, наймаанд саад болох шударга бус өрсөлдөөн болон бусад хэлбэрээр нэгдэх, хуйвалдах, гэрээ байгуулах нь хууль бус.

Энэ хуулиар хууль бус гэж заасан аливаа гэрээ байгуулсан, эсвэл аливаа нэгдэл, хуйвалдаанд оролцсон этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх ба ял шийтгэл оноохдоо шүүхийн шийдвэрээр аж ахуйн нэгжид 10,000,000 ам.доллараас илүүгүй торгууль ногдуулах, хувь хүнд 350,000 ам.доллараас илүүгүй торгууль ногдуулах эсвэл гурав хүртэл жилээр хорих, ба дээрх хоёр шийтгэлийг давхардуулан ногдуулна.

<sup>31</sup>[http://www.linfo.org/sherman\\_bxt.html](http://www.linfo.org/sherman_bxt.html)

**4. Шүүхийн шүүх эрх мэдлийн хүрээ (хэргийн харьяалал); Нэгдсэн Улсын шүүгчдийн үүрэг; процедур.**

Энэ хуулийн 1 дүгээр зүйлээс 7 дугаар зүйлд заасан зөрчлөөс урьдчилсан сэргийлэх болон таслан зогсоох эрхийг Нэгдсэн Улсын хэд хэдэн дүүргийн шүүхэд олгосон бөгөөд Ерөнхий прокурорын удирдамжийн дагуу эдгээр зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шүүх хуралдааныг тус тусын Муж улсдаа явуулах үүргийг Америкийн Нэгдсэн Улсын хэд хэдэн Муж улсын шүүгчид хүлээнэ.

Эдгээр шүүх хурал нь тухайн хэргийг мэдэгдэн, холбогдох хориг, шийдвэр гаргуулах эсвэл бусад байдлаар хориг арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн өргөдлийн дагуу явагдаж болно. Гомдол гаргагч талууд өргөдлөө зохих ёсоор ирүүлснээр шүүх нэн дариу хуралдаж, хэргийг байцаан шийдвэрлэх ба тухайн өргөдөл хүлээгдэж байх хугацаанд эсвэл эцсийн шийдвэр гарахаас өмнө Шүүхээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд түр зуурын хязгаарлах буюу хориглох арга хэмжээг аль ч үед авч хэрэгжүүлж болно.

**5. Нэмэлт талуудыг дуудаж ирүүлэх.**

Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу шүүх хурал болохоор хүлээгдэж байх үед шүүх ажиллагааг шударга явуулахад шаардлагатай бол бусад талуудыг тухайн шүүх хурал болох дүүрэгт оршин суудаг эсэхээс үл шалтгаалан шүүх хуралд дуудан ирүүлж болох ба энэ зорилгоор шүүхэд зарлан дуудах үүргийг дүүрэг бүрийн Маршал хэрэгжүүлнэ.

**6. Тээвэрлэгдэж байгаа өмчийг хураан авах.**

Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан гэрээ, нэгдлийн эзэмшил, хуйвалдааны улмаас олж авсан нэг Мужаас нөгөө Муж руу, эсвэл гадаад улс руу тээвэрлэж байгаа өмчийг Нэгдсэн Улсын мэдэлд хураан авах ба хууль зөрчин Нэгдсэн Улс руу импортолж буй өмчийг хураах, битүүмжлэх, саатуулах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид заасны хурааж, битүүмжилнэ.

**6а. Гадаад улстай хийх худалдаа арилжааг хамарсан үйл ажиллагаа.**

Гадаад улстай хийж байгаа худалдаа, арилжааны үйл ажиллагаанд (импортын наймаа болон импортын арилжаанаас бусад) энэ хуулийн 1 дүгээр зүйлээс 7 дугаар зүйл нь доор зааснаас бусад тохиолдолд үйлчлэхгүй.

- (1) Тухайн үйл ажиллагааны үр дагавар нь доор заасан үйл ажиллагаанд нөлөөлөх үр дагавар нь шууд, бодитой, харьцангуй урьдчилан харах боломжтой байх -
  - (А) Дотоод худалдаа арилжаа болон гадаад импортын худалдаа арилжаа, эсхүл
  - (В) Нэгдсэн Улсад экспортын худалдаа арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн экспортын худалдаа арилжаа;
- (2) Тухайн үр дагавар нь энэ хуулийн энэ зүйлээс бусад зүйлийн заалтын дагуу гомдол гаргахад хүргэсэн бол.

1 дүгээр зүйлээс 7 дугаар зүйлийн дагуу тухайн үйл ажиллагааг шийдвэрлэхдээ зөвхөн (1) (В) дэх заалтыг үндэслэсэн бол зөвхөн Нэгдсэн Улсын экспортын наймаанд гарсан хохирлын хувьд хэрэгжүүлнэ.

**7. “Хуулийн этгээд” болон “Хуулийн этгээдүүд” тодорхойлолт.**

“Хуулийн этгээд” болон “хуулийн этгээдүүд” гэсэн ойлголтыг энэ хуулийн 1 дүгээр зүйлээс 7 дугаар зүйлд хэрэглэгдэхдээ Америкийн Нэгдсэн Улсын хууль, аливаа Бүс нутгийн хууль, түүнчлэн аливаа Муж улсын хууль, эсвэл гадаад улсын хуулийн дагуу оршин байгаа, эсвэл үйл ажиллагаа явуулах эрх олгосон аж ахуйн нэгж болон холбоодыг багтаан ойлгоно.

**Робинсон-Патманы хууль: Үнийн ялгаварлал**

Клэйтоны хуулийн 2 дугаар хэсэг болон Робинсон-Патманы акт нь 1936 онд хүчин төгөлдөр болсноосоо хойш ихээхэн шүүмжлэлд өртөх болсон байна. Тус хуулиудыг шүүмжлэх гол аргумент нь:

- (А) Хуулийн хэл найруулга,
- (В) Тус хуулийн үйлчлэлийн үр дүнд бий болох үр дагаврын асуудал буюу эдгээр

хуулийн зохицуулалтын дагуу ААН-үүд хэрэглэгчдийг татахын тулд үнээ буулгахад саад болдгоороо өрсөлдөөний эсрэг зохицуулалт бүхий хууль тогтоомж болсон гэж баталдаг байна.

Гэвч, Робинсон-Патманы хуулийг шинэчлэн найруулах, хүчингүй болгох олон удаагийн оролдлого хийгдэж байсан ч тус хууль өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

Сүүлийн жилүүдэд Конгрессын Хуулийн хэлтэс нь тус хуулиудын хэрэгжилтийг хангахаас татгалзаж, Холбооны Худалдааны Комисст энэ хуулийн хэрэгжилтийг албадан хангуулах ажлыг даалгасан байна. Эдийн засгийн хувьд ямар ач холбогдолтойгоос үл хамаараад энэхүү хууль нь зах зээл судлаачдын хувьд бодит байдал асуудал болоод байгаа юм.

Клэйтоны хуулийн 2 дугаар хэсэг 1914 онд батлагдсан анхны хувилбар нь томоохон трест (large trusts)-ийн практик дахь үнэ бууруулах зорилготой байсан. Энэ нь бүтээгдэхүүний үнийг бүтээгдэхүүний өртгөөс нь бага байлгаж, тодорхой зарим байршилд иймэрхүү зардлыг удаан даахааргүй жижиг өрсөлдөгчдийг шахан гаргах зорилготой байсан.

Гэвч Клэйтоны хууль анх батлагдах үед байсан **“худалдан борлуулж буй бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамаарсан үнийн ялгавартай байдал”** гэсэн заалтуудыг хүчингүй болгосноор энэ хууль бодит байдалд арай илүү нийцэх болсон гэж судлаачид үзжээ. Учир нь энэ нь үнийн ялгаварлал байгаа гэдгийг батлахад ихээхэн хүндрүүлж байсан хуулийн цорхой байсан гэж үздэг байна.

1930 оны Их Хямрал үнийн ялгаварлалын талаар аюулын харанга дэлдсэнээр Конгрессыг үр дүнтэй, бодит арга хэмжээ авахад хүргэсэн. 1936 онд Конгресс Робинсон-Патманы актыг баталснаар Клэйтоны хуулийн 2-р хэсгийг бэхжүүлсэн байна. Томоохон худалдан авагчид өөрсдийн худалдан авах чадварыг хэрхэн ашиглах талаар болгоомжлолд хөтлөгдсөн ч бодит байдал дээр хуулийн ихэнх зохицуулалт нь худалдагчийн үнэ тогтоох үйл явц дээр төвлөрч байжээ.

**Хууль тогтоох үндэс хүрээ:** Хуулийн гол амин сүнс нь 2-р хэсгийн (а) заалт юм. Энэ нь дараах байдлаар томъёологдсон байдаг. Тодруулбал, “Худалдаанд оролцож буй аливаа хувь хүн, хуулийн этгээд нь хууль бус ... ижил нэр төрлийн болон ижил чанартай бараа бүтээгдэхүүн худалдан авч буй худалдан авагчдын дунд үнийн ялгавартай тогтоох ... ийм ялгаварлалын үр дүн нь өрсөлдөөнийг бодитоор буулгах эсвэл худалдааны аль ч түвшинд монополь тогтоох эсхүл хэн нэгэнтэй өрсөлдөөнийг алдагдуулах, устгах эсхүл түүнээс сэргийлэх байвал, мөн ийм ялгаварлалын үр шимийг ухамсартайгаар хүртсэн, эсвэл үйлчлүүлэгчдийн аль нь ч”<sup>32</sup> гэж заасан байдаг. Энэхүү хэсэг нь үнийн ялгаварлалын хариуцлагаас хамгаалах тодорхой замуудыг агуулдаг гэж АНУ-ын судлаачид үздэг байна. Жишээ нь “арга зам болон тоо хэмжээний ялгаанаас үүдэлтэй үйлдвэрлэл, худалдаа, хүргэлтийн өртгийн ялгаа байгаа тохиолдолд” үнийн ялгавар хүлээн зөвшөөрөгдөнө.

Энэ хэсэг нь мөн худалдагчийг зах зээлийн өөрчлөгдөж буй нөхцөл болон бүтээгдэхүүний таваарлаг чанараас хамааран үнээ өөрчлөхийг зөвшөөрдөг, жишээ нь хурдан муудах бүтээгдэхүүний чанар муудаж эхэлбэл худалдагч нь бүтээгдэхүүнийг хурдан борлуулах үүднээс үнийг буулгаж болно.

2-р хэсгийн (b) нь үнийн ялгаварлалын үндсэн хамгаалалтыг агуулдаг бөгөөд энэ нь “өрсөлдөөнийг хангаж шударгаар тогтоосон ямар ч үнэ хууль ёсны байна” гэсэн заалт юм.

<sup>32</sup> “[I]t shall be unlawful for any person engaged in commerce...to discriminate in price between different purchasers of commodities of like grade and quality...where the effect of such discrimination may be substantially to lessen competition or tend to create a monopoly in any line of commerce, or to injure, destroy or prevent competition with any person who either grants or knowingly receives the benefit of such discrimination, or with customers of either of them.”

**Худалдан борлуулагчийн ялгаварлал:** Үүний урьдчилсан асуудлууд нь худалдаа хийгдсэн цаг хугацаа буюу нэгэн зэрэг хийгдсэн худалдаа, худалдан авагчийн онцлог, бүтээгдэхүүн бараа үйлчилгээ гэх мэт олон зүйлээр нөхцөлдсөн байдаг.

**Тэгвэл худалдааны цаг хугацаа буюу нэгэн зэрэг хийгдэх худалдаа** нь нэг цагт хийгдсэн эсвэл цаг хугацааны хувьд хангалттай ойролцоо хийгдсэн худалдаанд гарах ёстой. Хангалттай ойр цаг хугацаа гэдэг нь үйлдвэрийн төрөл болон зах зээлийн нөхцөл байдлаас хамаардаг. Цаг хугацааны мөчлөг нь өдөр тутмын бүтээгдэхүүний хувьд компьютерийн бүтээгдэхүүнээс удаан байна. Энэ нь бүтээгдэхүүний мөн чанар, худалдааны давтамж, нэгжийн өртөг, зах зээлийн хувирах шинжээс хамаардаг.

**Бүтээгдэхүүний худалдаа:** Энэ хууль нь зөвхөн бараа бүтээгдэхүүний худалдааг зохицуулдаг. Бараа бүтээгдэхүүнийг түрээслэх, лизингээр авах болон лицензээр ашиглах нь худалдаанд хамаарагдахгүй. Иймээс эдгээрийн явцад гарах үнийн ялгавартай байдал нь Робинсон-Патманы хуульд хамаарахгүй бөгөөд хууль бус гэж тооцогдохгүй. Түүнчлэн, тус хууль нь зөвхөн бодит материаллаг бараа таваарын худалдааг зохицуулдаг учир лицензийн эрх, патентын эрх, хувьцаа зэрэг таваарлаг биш зүйлсийн худалдааг энэ хууль зохицуулахгүй гэж шүүх мэдэгдсэн.

**Ижил төрлийн болон ижил чанарын бүтээгдэхүүн:** Зөвхөн ижил төрөл чанарын бүтээгдэхүүнүүдийг хамарсан худалдаа нь үнийн ялгаварлалын хуулийн хүрээнд зохицуулагдана. Төрөл болон чанар нь “бүтээгдэхүүний өөрийн онцлог чанаруудаар” тодорхойлогдоно. Бүтээгдэхүүнүүд нь физик шинж чанар болон химийн найрлагаар ижил болон маркетингийн ажилчид нь тэднийг хэрхэн ялгах гэж оролдохоос үл хамааран ижил төрөл, чанарын гэж үзнэ. Гэвч бүтээгдэхүүний таваарлаг шинжид нөлөөлдөг физик шинж чанарын ялгаа нь бүтээгдэхүүнийг өөр төрөл чанарын гэж үзэхэд хүргэж болно. Ялгаа нь үл ялиг бөгөөд борлуулагчийн үйлдвэрлэлийн болон маркетингийн өртөгт нөлөөлөхгүй ч гэсэн адил.

**Өрсөлдөөнд учруулсан хор хөнөөл:** Робинсон-Патманы хуульд заасан худалдагчийн үнийн ялгаварлал гэдгийг тогтоохын тулд тус нөхцөл байдал нь өрсөлдөөний эсрэг үр дагавар үүсгэсэн байх ёстой. Энэхүү бий болсон үр дагавар нь өрсөлдөөнийг мэдэгдэхүйц бууруулах эсвэл монополь үүсгэх хандлагатай байвал хууль үйлчилнэ.

**Худалдагчийн хамгаалал:** Робинсон-Патманы хууль нь худалдагчид хоёр ерөнхий хамгаалалт бий болгосон байдаг. Үүнд:

- (А) Өртгийн тэнцэл,
- (В) Өрсөлдөөнд тэнцэхүйц байдал.

Хэрэв худалдагч нэг тодорхой худалдан авагчтай хийж буй худалдаанд нь бусад худалдан авагчтай хийсэн худалдаанаас доогуур үнэ санал болговол үнийн зөрүү нь өртгийн ялгаанд үндэслэгдсэн бол хүлээн зөвшөөрөгдөнө. Жишээ нь, хэрэв аль нэг худалдан авагч зардал хэмнэх үүднээс бараа таваарыг хямд контейнер эсвэл том савлагаатай авахыг хүсвэл энэхүү хэмнэлт нь худалдан авагчид очно. Худалдан авагч нь үйлдвэрлэгчид бүтэн жилийн захиалга өгч болох ба захиалгын тоо хэмжээ нь бусад худалдан авагчийнхаас хэд дахин их байвал, энэхүү их хэмжээний захиалга нь үйлдвэрлэгчид бараа таваараа харьцангуй буурсан өртгөөр үйлдвэрлэх боломжийг бий болгоно.

**Мерчандайзинг болон бусад үйлчилгээний хөнгөлөлт:** Робинсон-Патманы актын 2-р зүйлийн (б) болон 2-р зүйлийн (е) заалтууд нь худалдагчийг мерчандайзингд ялгавартай хөнгөлөлт үзүүлэх болон худалдан авагчид ялгавартайгаар бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглодог. Үнэ нь худалдан авагчийг татах ганц арга зам биш учир энэхүү заалтууд нь зайлшгүй шаардлагатай юм.

## **Гадаадын зарим улс орны өрсөлдөөний хуулийн зохицуулалт**

Дэлхийн улс орнуудын туршлагаас харахад өрсөлдөөний тухай хууль 19-р зууны сүүл, 20-р зууны эхнээс хуульчдын анхаарлыг татах болсон ба АНУ-д 1890 онд Шерманы хуулийг баталсан бол, 1896 онд Германд шударга бус өрсөлдөөний тухай хуулийг анх баталсан байна. Шударга өрсөлдөөний тухай хуулийг батлахад олон улсын гэрээ, хэлэлцээрүүд чухал үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, 1883 оны Аж үйлдвэрлэлийн өмчийг хамгаалах тухай Парисын Конвенцын 10 дугаар зүйлд шударга бус өрсөлдөөн гэх үйлдлүүдийг тодорхойлон дурдсан байна.

Олон жилийн турш ихэнх улс оронд шударга өрсөлдөөнийг иргэний хуулиар зохицуулж ирсэн түүхтэй ба олон улсын туршлагаас харахад шударга өрсөлдөөний ач холбогдлын талаар үзэл санаа төлөвшихөд багагүй хугацаа шаардагдсан байна.

Шударга өрсөлдөөнийг зохицуулах эрх зүйн нөхцөл дараах хандлагаар хөгжиж ирсэн байна: Эхэндээ монополь үйл ажиллагааг хязгаарлах, давамгайл байдалтай аж ахуйн үйл ажиллагааг төрөөс зохицуулахад чиглэсэн байв. Дараа нь шударга өрсөлдөөний хуулиар бусад аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулах, тухайлбал, компаниуд нэгдэх, бусад компаниудын хувьцааг худалдаж авах зэрэг ажиллагааг зохицуулдаг болжээ. Цаашдаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, шударга өрсөлдөөнд оролцож буй аж ахуйн нэгжийн нэр төрийг хамгаалах, бусад хууль тогтоомжтой нягт уялдуулах болсноос гадна шударга өрсөлдөөнийг хянан зохицуулах байгууллагад илүү эрх мэдэл олгож тэдгээрийн байр суурийг бэхжүүлэх хандлага улам нэмэгдэх болсон.

Монополийг зохицуулсан эрх зүйн зохицуулалтын тогтолцоог монопольд тавих хяналтын хувьд Америк болон Европ гэж хоёр хувааж болох юм. Америк тогтолцоо нь монополийг хориглодог бол Европ тогтолцоо нь монополиуд зах зээл дахь давамгайл эрхээ хэтрүүлэх асуудалд төрөөс хяналт тавих зарчим дээр суурилсан байна. Америк тогтолцоотой улс орнуудад АНУ, Канад болон Аргентин зэрэг ордог бол, Европ тогтолцоотой улс орнууд нь Баруун Европын улс орнуудаас гадна Австрали, Шинэ Зеланд болон Өмнөд Африк зэрэг улс орнууд байна. Харин Герман болон Япон зэрэг орнууд нь дээрхийн аль алинд хамаарахгүй бөгөөд зарчмын хувьд монополийг хориглосон боловч, тодорхой нөхцөлтэйгөөр зөвшөөрдөг байна.

1960-аад оны дунд үер хийсэн судалгаанд дэлхийд нийт 24 улс монополийн эсрэг хууль, тогтоомж баталсан байна гэж дурджээ. 1973-1989 оны хооронд 17 улс нэмэгдсэн нь ихэвчлэн Европын орнууд байсан бол 1990-1996 оны хооронд 26 орон монополийн эсрэг хууль, тогтоомж баталснаар одоогийн байдлаар нийт 100 орчим орон монополийн эсрэг хууль, тогтоомжтой байна.

### **1. Европын холбоо**

Монополийн эсрэг нийтлэг нормыг Европын холбооны нэгдсэн зах зээлтэй Европын Холбоог байгуулах Ромын гэрээнд заасан байна. Түүнчлэн, Европын холбооны зөвлөл ба Комиссын гаргасан тогтоол, удирдамж болон шүүхийн практик зэрэг нь өрсөлдөөний эрх зүйн эх сурвалжид тооцогддог байна. Шударга өрсөлдөөнийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь Европын нэгдсэн зах зээлийн үндэс суурь болохоос гадна, нэгдсэн зах зээл бий болгоход чиглэсэн худалдаанд саад учруулахгүй байх, ялгаварлахгүй байх зэрэг зарчим дээр суурилсан болно. Өнөөдрийн байдлаар Европын холбооноос өрсөлдөөний талаар баримтлах бодлого нь дараах салбаруудад чиглэж байна. Үүнд: картелийн үйл ажиллагаа; давамгайл байдалтай аж ахуйн нэгж зах зээлд ноёлох үйл ажиллагаа явуулах; үйлдвэрлэлийн төвлөрлийг хянах; гишүүн орнуудын хувьд төрөөс олгох зээл, тусламжид хяналт тавих зэрэг байна.

Европын монополийн эсрэг эрх зүйн зохицуулалт нь шударга өрсөлдөөнийг нэн чухалчлахын зэрэгцээ томоохон, ихэвчлэн технологийн инновацийг дэмжигч байгууллагуудын өөхшүүлж ирсэн харилцан зөрчилдөх нөлөөн дор бүрэлдсэн байна. Иймд өрсөлдөөнд хандах хандлагыг нь дундыг барьсан монополийг хянахдаа монополь үүссэн эсэх гэхээсээ илүү монополь эрхээ хэтрүүлсэн эсэх тал дээр түлхүү анхаардаг байна.

Европын холбооны хувьд анх 1969 онд өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл (картель)-тэй холбоотой шийдвэр гарснаас 2013 он хүртэлх хугацаанд Европын комиссоос нийт 820 компанид 19 тэрбум гаруй евротой тэнцэх хэмжээний торгууль ногдуулсан байна.

### ***Үнийг хэлцэн тогтоох, үнийн ялгаварлалтай холбоотой зохицуулалт***

Европын холбооны үйл ажиллагааны гэрээ (Article 101 TFEU)<sup>33</sup> -ний 101 дүгээр зүйлд “Гишүүн орнуудын хороон дахь худалдаанд нөлөөлөх, Европын холбооны зах зээл дэх шударга өрсөлдөөнд харшлах, өрсөлдөөнийг хязгаарлах, эсхүл гажуудуулах зорилго болон үр дүнд хүрэх аж ахуй эрхлэгчдийн хоорондох бүхий л гэрээ, хэлцэл, аж ахуйн эрхлэгчдийн холбоодын шийдвэр болон тохиролцсон үйл ажиллагааг Европын холбооны зах зээлд харшлах үйлдэл гэж үзэн, хориглоно” гэж заасан байна. Нэг төрлийн бараа бүтээгдэхүүнийг ялгавартай үнээр борлуулах, ялгавартай нөхцөл бүрдүүлэхийг 102 дугаар зүйлээр хориглосон байна.

## **2. БНХАУ**

БНХАУ-ын Монополийн эсрэг хуулийн төслийг анх 1987 онд Төрийн зөвлөлийн Хууль зүйн хорооноос байгуулагдсан ажлын хэсэгт боловсруулахыг даалгасан ба 1988 онд Монополийн эсрэг болон шударга бус өрсөлдөөний тухай түр журмын тогтоолыг төслийг боловсруулсан байна. Үүнээс хойш 10 гаруй жилийн турш хуулийн төслийг боловсруулсны эцэст 2007 онд Монополийн эсрэг хууль (Anti-Monopoly Law)-ийг 8 бүлэг, 57 зүйлтэй батлагдаж, 2008 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна. Тус хуулийг Европын холбооны болон АНУ-ын хуулийг суурь болгосон ба дараах үйл ажиллагааг зохицуулсан байна. Үүнд:

1. Тодорхой нөхцөлтэйгөөр зөвшөөрөгдсөнөөс бусад тодорхой төрлийн гэрээ, хэлцүүдийг хориглох (2 дугаар бүлэг),
2. Давамгай байдлаа хууль бусаар ашиглах ангилалд багтах тодорхой үйл ажиллагаа явуулахыг хориглох (3 дугаар бүлэг),
3. Зах зээлийн төвлөрлийг хянах (4 дүгээр бүлэг),
4. Төрөөс өрсөлдөөнийг хязгаарлах эрхээ хэтрүүлэх ашиглахыг хориглох (5 дугаар бүлэг) зэргээс бүрдэж байна.

Хуулийн сүүлийн хэсэгт хууль тогтоомжийг зөрчигчид ногдуулах торгууль, оюуны өмчийн эрхээ хэтрүүлэн ашиглах зэрэг асуудлыг тусгасан байна. Хуулийн үйлчлэх хүрээ нь нэлээд өргөн бөгөөд тус хууль нь бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон борлуулагч, үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, хуулийн этгээд болон бусад байгууллагыг хамаарах ба мөн хуулийн 7 дугаар зүйлд Төрийн өмчит компанийг хамаарах тухай “бүрхэг” заалт орсныг Монополийн эсрэг хуулийг өмчлөлийн хэлбэрээс үл хамаарах адил тэгш үйлчилнэ гэж ойлгож болохоор байна. Үүнээс гадна тус хууль нь газар зүйн хувьд өргөн хүрээнд үйлчлэх ба БНХАУ (Хонконг, Макао болон Тайваныг оролцуулахгүй) дахь өрсөлдөөнийг хязгаарласан гэж тогтоовол, БНХАУ-ын газар нутгаас гадуур үйлдэгдсэн ч Монополийг эсрэг хуулийг зөрчсөнд тооцогдоно.

<sup>33</sup>Treaty on Functioning of the European Union, <http://eur-lex.europa.eu/>

Монополийн эсрэг хууль нь БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр өрсөлдөөнийг хамгаалахад чиглэсэн гурван хуулийн нэг ба бусад хоёр нь 1998 онд батлагдсан Үнийн тухай хууль болон 1993 онд батлагдсан Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль юм.

***Үнийг хэлцэн тогтоох, үнийн ялгаварлалтай холбоотой зохицуулалт***

Монополийн эсрэг хуульд Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ) болон Аж үйлдвэр, худалдааны төрийн захиргааны удирдлагын газар (АҮХТЗУГ)-ын тус хуультай холбоотой хэрэгжүүлэх эрх мэдлийг тодорхой зааж өгсөн байдаг ч өрсөлдөөнийг хязгаарласан тодорхой төрлийн үйл ажиллагааны хувьд давхардсан байдал ажиглагддаг. Тодруулбал, ҮХШХ нь үнийн асуудалтай холбоотой өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ, хэлцэл (хэвтээ хэлцэл болон бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тодорхой түвшинд хадгалах)-тэй холбоотой, харин АҮХТЗУГ нь үнийн бус хязгаарлалт болон зах зээлийг хуваах, үйлдвэрлэлийг хязгаарлах, болон бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг хадгалахаас бусад босоо хэлцэлтэй холбоотой асуудлыг тус тус хариуцдаг юм. ҮХШХ болон АҮХТЗУГ нь Монополийн эсрэг хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхээс гадна Шударга бус өрсөлдөөний эсрэг хууль болон Үнийн тухай хуультай холбоотой эрх мэдлийг хэрэгжүүлнэ. Монополийн эсрэг хуулийн 13 дугаар зүйлд үнэ тогтоох (хэлцэн тогтоох), үйлчлүүлэгч/зах зээлийг хуваах, үйлдвэрлэлийг хязгаарлах болон нэгдсэн эсэргүүцэл зэргийг хориглосон байна. Хэвтээ гэрээ, хэлцэл нь бичгээр эсхүл аман гэрээ, хэлцэл байх албагүй бөгөөд төрөл бүрийн хэлбэртэй байж болох юм.

Тус хуулийн 13 дугаар зүйлийн дагуу өрсөлдөгч аж ахуй эрхлэгчид хоорондоо бараа, бүтээгдэхүүний үнэ тогтоох болон өөрчлөх монополийн гэрээ байгуулахыг хориглохоор заасан байна. 14 дүгээр зүйлийн дагуу аж ахуй эрхлэгч болон харилцагч талууд хоорондоо бараа бүтээгдэхүүний үнийг тогтоох болон өөрчлөх монополийн гэрээ байгуулахыг хориглохоор тус тус заасан байна. “Монополийн гэрээ” гэх нь өрсөлдөөнд харш, өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн аливаа гэрээ, хэлцэл, шийдвэр болон тохиролцоонд хүрэхэд чиглэсэн бусад үйл ажиллагааг хэлнэ.

Үнийн ялгаварлалтай тухай болох Монополийн эсрэг хуулийн 17 дугаар зүйлийн 6-д давамгайл байдлаар аж ахуйн нэгж нь ялгавартай үнэ тогтоох болон бусад гүйлгээний нөхцөл шаардах зэрэг ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасан байна.

Монополийн эсрэг хуулийн дагуу өрсөлдөөнийг хязгаарласан аман гэрээ, шийдвэр, эсхүл хэлэлцээрийг хориглоно. Үүнд:

- үнэ тогтоох;
- үйлдвэрлэл, эсхүл худалдааг хязгаарлах;
- худалдаа явуулах зах зээл, эсхүл түүхий эдийн зах зээлийг хуваах;
- шинэ технологи, эсхүл тоног төхөөрөмж худалдан авах, эсхүл хөгжүүлэхийг хязгаарлах;
- нэгдсэн эсэргүүцэл (collective boycotts);
- дистрибүтерийн гэрээнд жижиглэнгийн үнийн дээд, эсхүл доод хэмжээг тогтоох;
- холбогдох байгууллагуудаас тогтоосон бусад үйл ажиллагаа.

Тодорхой шалтгаанаар байгуулсан гэрээ үүнд үл хамаарна. Жишээ нь: технологи шинэчлэх, эсхүл шинэ бүтээгдэхүүн гаргахтай холбоотой судалгаа болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үнийг бууруулах, үр дүнг дээшлүүлэх, жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааны үр дүн болон өрсөлдөх чадварыг дээшлүүлэх болон бусад холбогдох нөхцөлүүдийг тусгасан байна.

Монополийн эсрэг хуулиас гадна 1998 онд батлагдсан Үнийн тухай хуульд зарим төрлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэт өндөр үнийг бууруулах, тодорхой түвшинд тогтоох

арга хэмжээ хэрэгжүүлэх зүйл, заалтууд тусгагдсан байна. Тухайлбал, дээд үнийн хязгаарыг тогтоох, ашгийн хэмжээ тогтоох зэрэг арга хэрэгслүүд орж байна. Зарим онцгой тохиолдолд, бараа, үйлчилгээний үнийг тогтоох, үнийн зарим хэсгийг, эсхүл бүхэлд нь царцаах арга хэмжээ авч болох байна.

1998 онд батлагдсан БНХАУ-ын *Үнийн тухай хуулийн 18 дугаар зүйлд*: “Ихэнх бараа, үйлчилгээний үнийг зах зээлийн зарчмаар тогтооно, харин тодорхой цөөн тооны бараа үйлчилгээний үнийг засгийн газраас тогтооно” гэж заасан байна. Тус хуулийн *18 дугаар зүйлд* Засгийн газраас дараах бараа, үйлчилгээний үнийг тогтооно. Үүнд: улс орны эдийн засгийг хөгжүүлэх, ард иргэдийн сайн сайханд зайлшгүй шаардлагатай цөөн тооны бараа, түүхий эд нь хомс, цөөн тооны бараа, зүй ёсны монополийн бараа бүтээгдэхүүн, чухал нийтийн үйлчилгээний бараа, нийгмийн халамжийн үйлчилгээний бараа бүтээгдэхүүн зэрэг орж байна.

### 3. ОХУ

ОХУ-д монополийн эсрэг эрх зүйн зохицуулалт харьцангуй богино түүхтэй бөгөөд 90-ээд оны эхэн үеэс үүссэн ба эдийн загийн нөхцөл байдлыг ялгаатай байдлыг үл харгалзан Америкийн монополийн эсрэг эрх зүйн зохицуулалтыг суурь болгосон байна.

ОХУ-ын Өрсөлдөөнийг хамгаалах тухай хууль нь 2006 онд 10 бүлэг, 54 зүйлтэй батлагдсан. Тус хууль нь дараах бүлэгтэй байна. Үүнд: 1. Ерөнхий зүйл; 2. Монополь үйл ажиллагаа болон шударга бус өрсөлдөөн; 3. Төрийн байгууллага болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн төсвийн бус сангууд, Холбооны Төв Банк зэргийн өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн эрх зүйн акт, хэлцэл, үйл ажиллагааг хориглох; 4. Худалдаа, ялангуяа санхүүгийн байгууллагыг сонгоход монополийн эсрэг шаардлага тавих; 5. Төрийн болон орон нутгийн тусламж; 6. Монополийн эсрэг байгууллагын үүрэг, бүрэн эрх; 7. Эдийн засгийн төвлөрөлд тавих төрийн хяналт; 8. Монополийн эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага; 9. Монополийн эсрэг хуулийг зөрчсөн үйл ажиллагааг хянан шалгах; 10. Бусад зүйл.

Энэхүү хуулийн гол зорилт нь ОХУ-д эдийн засгийн нэгдмэл орон зай бий болгох, бараа бүтээгдэхүүний чөлөөтэй эргэлтийг бий болгох, эдийн засгийн үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнийг хамгаалах болон зах зээлийн үр дүнтэй үйл ажиллагааг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн үйлчлэл нь өргөн хүрээтэй байх ба ОХУ дахь өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа, эсхүл хязгаарлах үр дүнд хүргэх магадлалтай бол ОХУ-ын газар нутгаас гадуур оросын, эсхүл гаднын этгээд буюу байгууллагууд хооронд байгуулсан гэрээ, хэлцлүүд хамаарна.

#### ***Үнийг хэлцэн тогтоох, үнийн ялгаварлалтай холбоотой зохицуулалт***

Өрсөлдөөнийг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд давамгайл байдалтай аж ахуйн нэгж эрх мэндлээ хэтрүүлэн дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

- 10.1. Бараа бүтээгдэхүүний хэт өндөр, эсхүл хэт бага үнэ тогтоох, үнийг тодорхой түвшинд хадгалах.
- 10.6. Холбооны хуульд өөрөөр заагаагүй бол нэг төрлийн бараа, бүтээгдэхүүнд эдийн засгийн, технологийн, эсхүл өөр ямар нэгэн үндэслэлгүйгээр ялгаатай үнэ, тариф тогтоохыг;
- 10.8. Ялгаварласан нөхцөл бүрдүүлэх;
- 10.10. Хууль, эрх зүйн актаар тогтоосон үнэ бүрэлдэх журмыг зөрчсөн зэрэг үйл ажиллагаанууд орж байна.

Өрсөлдөөнийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлд нэг төрлийн бараа, бүтээгдэхүүний зах зээл дээр борлуулалт, нийлүүлэлт хийж байгаа өрсөлдөгч аж ахуйн нэгжүүд хоорондоо гэрээ хэлцэл хийн доорх үр дүнд хүрч байгаа нөхцөлд картель гэж тооцон хориглоно.

- 11.1. Үнэ / тариф, хөнгөлөлт, нэмэгдэл тодорхой түвшинд тогтоох, барих;
- 11.2. Бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах, нэмэх, тодорхой түвшинд тогтоох;
- 11.3. Бараа, бүтээгдэхүүний зах зээлийн газар зүйн байрлалаар, борлуулалт, нийлүүлэлтийн хэмжээгээр, болон бараа бүтээгдэхүүний төрөл болон борлуулагч буюу худалдан авагчдыг хэсэгчлэн хуваах;
- 11.4. Зарим борлуулагч, эсхүл худалдан авагчидтай гэрээ байгуулахаас татгалзах зэрэг болно.

#### **4. Канад**

Канадын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт нь АНУ-ын Шерманы хуулиас түрүүлж 1889 онд батлагдсан бөгөөд хамгийн анхны өрсөлдөөний тухай хууль юм. Одоо мөрдөгдөж байгаа Өрсөлдөөний тухай хууль 1985 онд батлагдсан нь 10 бүлэг, 128 зүйлтэй батлагдсан байна. Тус хуулийн зорилго нь Канад улс дахь өрсөлдөөнийг дэмжсэнээр олон улсын зах зээл дэх Канадын оролцоог нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрүүдэд зохих боломж бололцоо олгох болон хэрэглэгчдийг бараа сонголт болон боломжит үнээр хангахад оршино.

Өрсөлдөөний хуулийн 45, 46 болон 48 дугаар заалтад хоёр буюу түүнээс дээш этгээд хэлцэн тохиролцож өрсөлдөөнийг хууль бусаар хязгаарлах, үндэслэлгүйгээр бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэх зэргийг хориглосон байна. Өрсөлдөөний тухай хуулийн 50, 51 дугаар заалтад үнийг ялгавартай тогтооход эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг 2009 онд хүчингүй болгосон байна. Энэ нь 2008 оны дэлхийн эдийн засгийн хямралын эсрэг, эдийн засгийн эрчимжүүлэх бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ байсан байна. Үнийн ялгаварлалтыг Өрсөлдөөний тухай хуулийн 79 дүгээр заалтад заасан давамгайл байдлаар аж ахуйн нэгж давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаанд хамруулж болох бөгөөд өмнөх зохицуулалттай харьцуулахад харьцангуй зөөлөн болсон гэж хэлж болно.

#### ***Канадын зарим бараа бүтээгдэхүүний үнэд тавьж буй хяналт (газрын тосны бүтээгдэхүүний тухайд)***

Канадын Өрсөлдөөний товчоо нь Өрсөлдөөний хуулийг хэрэгжүүлэх байгууллага бөгөөд хэлцэн тохирон үнэ тогтоох, үнийг тодорхой түвшинд барих болон давамгайл эрхтэй аж ахуйн нэгж ноёлох үйл ажиллагаа явуулах зэрэг үйл ажиллагааг хянах юм. Дээрх бүх үйл ажиллагаанууд нь газрын тосны бүтээгдэхүүний зах зээлд хамаарах юм. Өрсөлдөөний хуулиар Товчоо нь үнийг тохируулах эрх эдлэхгүй ба Холбооны засгийн газар нь улс оронд онц байдал тогтоосноос бусад тохиолдолд газрын тосны бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг хуульчлан тогтоох эрхгүй байна. Газрын тосны жижиглэнгийн худалдааны үнийг орон нутгийн засгийн газар тогтоох эрхтэй байдаг. Ийнхүү Ханхүү Эдвардын арал, Ньюфаундленд ба Лабрадор, Нова Скотиа, Шинэ Брунсвик болон Квебек зэрэг муж улсууд нь газрын тосны бүтээгдэхүүний үнийг ямар нэгэн байдлаар зохицуулсан байгаа бол бусад муж улс нь зах зээлийн үнийг илүүд үзсэн байна.

Газрын тосны үнийг ямар нэгэн байдлаар зохицуулах нь түлшний үнийг бууруулахад дорвитой нөлөө үзүүлээгүй, харин үнэ тогтворжиход эерэг нөлөө үзүүлсэн байна.

**Ханхүү Эдвардын арал:** Тус арлын Зохицуулах болон маргаан хянан шийдвэрлэх комисс нь автомашины түлш, ахуйн халаалтын түлш, пропан зэргийн бөөний болон жижиглэнгийн үнийг хянадаг байна. Комисс нь үнийг хэр ойрхон болон хэдийд өөрчилж

болохыг шийдэхээс гадна бөөний болон жижиглэнгийн үнийн дээд болон доод хязгаарыг тогтоож өгдөг байна. Жижиглэнгийн худалдаачид нь бүтээгдэхүүнийг үнийг нэмэхдээ зөвшөөрөл авах ба ингэхдээ үнэ өсгөж байгаа шалтгаан, үндэслэлээ тодорхой заах ёстой байна.

**Ньюфаундленд болон Лабрадор:** Газрын тосны үнийн алба нь Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд заасны дагуу түлшний үнийг тогтоодог байна. Тус алба нь бензин, дизель, ахуйн хэрэглээний түлшний жижиглэнгийн худалдааны дээд үнийг тогтоох ба ногдох татварын хэмжээг тогтоодог байна. Жижиглэнгийн худалдаачид нь тогтоосон үнээс дээш үнэ тогтоох эрхгүй байдаг. Газрын тосны бүтээгдэхүүний үнийг 2 долоон хоног тутам болон зах зээлийн нөхцөлд байдалд тохируулан тогтоодог байна.

**Квебек:** Гурван жил бүр Rйgie de l'йnergie жижиглэнгийн худалдаачны үйлдвэрлэлийн зардлыг нөхөхөд шаардагдахуйц бензин болон дизелийн жижиглэнгийн нэмэгдэл үнийн доод хэмжээг тогтоодог байна. Тус байгууллагаас тухайн нэмэгдэл үнэ нь жижиглэнгийн доод үнийг тогтооход хэрэглэгдэх нийт зардалд орох эсэхийг тооцдог байна. Доод үнийг бөөний үнэд үндэслэн тогтоох ба энэ нь тээврийн зардал, ногдох татвар болон ашгийн нийлбэр байна. Жижиглэнгийн үнэ нь тогтоосон доод хэмжээнээс дээш байх ёстой байна.

## 5. ИБУИНВУ

Их Британи улс нь 1998 онд Өрсөлдөөний тухай хуулийг (Competition Act), 2002 онд Аж ахуйн нэгжийн тухай хуулийг (Enterprise Act) тус тус баталсан бөгөөд эдгээр нь өнөөгийн Их Британи улсын шударга өрсөлдөөний эрх зүйн үндсэн эх сурвалж болдог.

“Өрсөлдөөний тухай” хуулийг боловсруулахдаа Ромын гэрээний 81, 82 дугаар зүйлийг баримталсан ба энэ хууль 4 үндсэн хэсгээс бүрдсэн байна. Үүнд:

1. Шударга өрсөлдөөнд харшлах үйлдлүүд, тухайлбал, гэрээ, хэлцэл байгуулах, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах, мөн шударга бус өрсөлдөөний талаар хэргийг шалгах, хууль бус үйлдэлд ногдуулах хариуцлага зэргийг.
2. Ромын гэрээний 85, 86 дугаар зүйлтэй холбоотой мөрдөн байцаах ажиллагаа явуулах талаар,
3. Монополийн талаар,
4. Нэмэлт асуудлыг тус тус зохицуулсан байна.

Их Британид 2002 онд Аж ахуйн нэгжийн тухай хууль батлагдсан бөгөөд шударга бус өрсөлдөөнтэй холбоотой компаниудын нэгдэх, нийлэх зэрэг асуудлыг тус хуулиар зохицуулсан байна.

1998 оны Өрсөлдөөний тухай хууль болон 2002 оны Аж ахуйн нэгжийн хуулиар Шударга худалдааны газар, Шударга өрсөлдөөний комисс, Шударга өрсөлдөөний давж заалдах шатны шүүх байгуулагдсан байна. Шударга худалдааны газар (Fair trade office) нь зах зээлийн үйл ажиллагаанд оролцогч талуудад таатай нөхцөлийг бүрдүүлэх, шударга өрсөлдөөнд оролцох эрхийг нь хангах ажлыг зохион байгуулах, үүний дотор бизнесийн байгууллагад худалдааны болон шударга өрсөлдөөний хуулийг хэрэглэх талаар зөвлөгөө өгөх эрхтэй байдаг. Шударга худалдааны газар нь 1998, 2002 оны хуулиудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ компаниудын захирлыг албан тушаалаас нь чөлөөлүүлэх хүртэл арга хэмжээ авах эрх мэдэлтэй.

Шударга өрсөлдөөнд харш нөхцөл үүссэн гэж үзвэл Худалдааны газар нь Өрсөлдөөний комисст (Competition commission) тухайн нөхцөл байдлыг шалгуулахаар хандаж болно. Өрсөлдөөний комисс нь компаниуд нэгдэх, тэдний дотоод дүрэм журмыг шалгах, мөн холбогдох этгээдээс шударга өрсөлдөөний талаар асуух, түүний дараа өөрийн бие

даасан дүгнэлтээ гаргаж болдог. Ийм төрлийн шалгалтыг Худалдаа, үйлдвэрийн сайд нь Өрсөлдөөний комисст даалгаж болохыг хуульд заасан байдаг. Харин Өрсөлдөөний комисс өөрөө шалгалт явуулахыг санаачлах эрхгүй.

Давж заалдах шатны шүүх (Competition Appeal Tribunal) нь 1998 оны хуулиар байгуулагдсан бөгөөд талуудын маргаан, Шударга худалдааны газраас гаргасан шийдвэрийг давж заалдах гомдлыг авч хэлэлцэх эрхтэй байна.

### **Үнийг хэлцэн тогтоох, үнийн ялгаварлалтай холбоотой зохицуулалт**

ИБУИНВУ-ын үнийг ялгаварлан тогтоохтой холбоотой заалт нь Европын холбооны холбогдох зохицуулалтад үндэслэгдсэн байна. Өрсөлдөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд заасны дагуу ИБУИНВУ дахь худалдаанд нөлөө үзүүлэх, ИБУИНВУ дахь өрсөлдөөнд харшлах, хязгаарлах, эсхүл гажуудуулах зорилго, үр дүн бүхий дараах гэрээ, хэлцэл, шийдвэр, үйл ажиллагаа зэргийг хориглоно. Үүнд: шууд болон шууд бусаар худалдах болон худалдан авах үнийг тогтоох, эсхүл худалдааны бусад нөхцөлүүдийг тогтоох; Үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээл, техникийн дэвшил эсхүл хөрөнгө оруулалтыг хязгаарлах, эсхүл хянах; Зах зээл, эсхүл нийлүүлэлтийн эх үүсвэрийг хуваах; Харилцагч талуудад харилцан адил биш ялгавартай нөхцөл бүрдүүлэх; Бусад талуудтай гэрээ хэлцэл хийхдээ, гэрээнд хамаарахгүй нөхцөл шаардах зэрэг болно.

ИБУИНВУ-ын өрсөлдөөний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2-т заасны дагуу давамгай байдалтай аж ахуйн нэгж дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Үүнд: Шууд болон шууд бусаар шударга бус худалдах болон худалдан авах үнэ тогтоох, эсхүл бусад шударга бус худалдааны нөхцөлийг бүрдүүлэх; Хэрэглэгчдэд хохирол учруулахуйц хэмжээнд үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээл болон техникийн дэвшлийг хязгаарлах; Харилцагч талуудад харилцан адил биш ялгавартай нөхцөл бүрдүүлэх; Бусад талуудтай гэрээ хэлцэл хийхдээ, гэрээнд хамаарахгүй нөхцөл шаардах зэрэг болно.

Одоогийн байдлаар эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэй ихэнх орнууд болон ардчилсан тогтолцоонд шилжиж буй хуучин социалист байсан ихэнх орон шударга өрсөлдөөний тухай хуультай болсон байна.

Ихэнх орнууд, ялангуяа өндөр хөгжилтэй орнууд шударга өрсөлдөөний талаар өөр өөрийн хуультай бөгөөд тэдгээр нь харилцан адилгүй байдаг. Гэсэн хэдий ч тэдгээр орнууд дараах нийтлэг зохицуулалтыг хийж, шударга өрсөлдөөнд харш дараах үйл ажиллагааг хориглосон байна:

1. Компаниуд үгсэн хуйвалдахын эсрэг буюу картелийн эсрэг үйл ажиллагааг, жишээлбэл, тодорхой бараа бүтээгдэхүүний үнийг тохиролцох замаар тогтоох, зах зээлийг хуваах, шинэ өрсөлдөгч гарч ирэхэд саад учруулах, нийлүүлэгч болон борлуулагчийг үндэслэлгүйгээр ялгавартайгаар сонгох зэрэг үйлдлийг хориглосон байна
2. Давамгай байдалтай аж ахуйн нэгж эрх мэдлээ урвуулан ашиглахын эсрэг эрх зүйн зохицуулалт хийж, давамгай байдалтай аж ахуйн нэгж нь бусад өрсөлдөгч болон хэрэглэгчдэд сөрөг үр нөлөө авчирч болзошгүй байдаг тул хуулиар давамгай байдалтай аж ахуйн нэгж нэг төрлийн бүтээгдэхүүнд ялгавартай үнэ тогтоох зэрэг зарим үйл ажиллагааг хориглосон байна.

\*\*\*

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

## Хууль

- Anti-monopoly Law of the People's Republic of China, 2008, [http://www.china.org.cn/government/laws/2009-02/10/content\\_17254169.htm](http://www.china.org.cn/government/laws/2009-02/10/content_17254169.htm), /last accessed June 9, 2014/
- Clayton Act, <http://www.antitrustlaws.org/Clayton-Act.html>
- Scherman Act, [http://www.linco.org/sherman\\_txt.html](http://www.linco.org/sherman_txt.html)
- U.S. Code: Title 15-Commerce and Trade, <http://www.law.cornell.edu/uscode/text/15/12>

## Судалгаа

- Connor, John M. *Global Price Fixing*, 2007 Springer
- Connor, John m. *Global Price Fixing: Our Customers are the Enemy*, 2002 Kluwer Academic Publishers
- Global Competition Review, *The Asia-Pacific Antitrust Review 2014*, <http://globalcompetitionreview.com/reports/> /last accessed June 6, 2014/
- *Global Competition Review, The European Antitrust Review 2014*, <http://globalcompetitionreview.com/reports/> /last accessed June 6, 2014/

## Хавсралт 1.

ЗАРИМ ГАДААД УЛС ОРНУУДЫН ҮНЭ ТОГТООХТОЙ БОЛОН ҮНИЙН  
ЯЛГАВАРЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

№	Улсын нэр	Өрсөлдөөнийг зохицуулсан хуулийн нэр, батлагдсан огноо	Үнийг хэлцэн тогтоох (картелийн) асуудлыг хуулиар зохицуулсан эсэх	Үнийн ялгаварлалын асуудлыг хуулиар зохицуулсан эсэх
1	Европын холбоо	Европын холбооны үйл ажиллагааны гэрээ	101-р зүйлд заасны дагуу гишүүн орнуудын хороон дахь худалдаанд нөлөөлөх, Европын холбооны зах зээл дахь шударга өрсөлдөөнд харшлах, өрсөлдөөнийг хязгаарлах, эсхүл гажуудуулах зорилго болон үр дүнд хүрэх аж ахуй эрхлэгчдийн хоорондох бүхий л гэрээ, хэлцэл, аж ахуйн эрхлэгчдийн холбоодын шийдвэр болон тохиролцсон үйл ажиллагааг Европын холбооны зах зээлд харшлах үйлдэл гэж үзэн, хориглоно	102.2-т заасны дагуу нэг төрлийн бараа, үйлчилгээний хувьд харилцагчдад ялгавартай нөхцөлд шаардан шударга бус өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэхийг хориглоно.
2	БНХАУ	Монополийн эсрэг хууль 2008 он	13, 14-р зүйлд заасны дагуу өрсөлдөгч аж ахуй эрхлэгчид хоорондоо бараа, бүтээгдэхүүний үнэ тогтоох болон өөрчлөх монополийн гэрээ байгуулахыг хориглох; Аж ахуй эрхлэгч болон харилцагч талууд хоорондоо бараа бүтээгдэхүүний үнийг тогтоох болон өөрчлөх монополийн гэрээ байгуулахыг хориглохоор тус тус заасан байна.	17.6. Давамгайл байдлаар аж ахуйн нэгж нь ялгавартай үнэ тогтоох болон бусад гүйлгээний нөхцөл шаардах зэрэг ноёлох үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3	ОХУ	Өрсөлдөөнийг хамгаалах тухай хууль 2006 он	<p>11-р зүйлд заасны дагуу нэг төрлийн бараа, бүтээгдэхүүний зах зээл дээр борлуулалт, нийлүүлэлт хийж байгаа өрсөлдөгч аж ахуйн нэгжүүд хороондоо гэрээ хэлцэл хийн доорх үр дүнд хүрж байгаа нөхцөлд картель гэж тооцон хориглоно.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. үнэ / тариф, хөнгөлөлт, нэмэгдэл тогтоох, барих;</li> <li>2. бараа, бүтээгдэхүүний үнийг бууруулах, нэмэх, тогтоох;</li> <li>3. бараа, бүтээгдэхүүний зах зээлийн газар зүйн байрлалаар, борлуулалт, нийлүүлэлтийн хэмжээгээр, болон бараа бүтээгдэхүүний төрөл болон борлуулагч буюу худалдан авагчдыг хэсэгчлэн хуваах;</li> <li>4. бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хумих, эсхүл зогсоох;</li> <li>5. зарим борлуулагч, эсхүл худалдан авагчидтай гэрээ байгуулахаас татгалзах зэрэг болно.</li> </ol>	11.6. Шударга өрсөлдөөнийг хязгаарласан аливаа гэрээ, хэлцлийг хууль бус гэж үзэх ба ингэхдээ нэг төрлийн бараанд эдийн засаг, технологи болон бусад ямарваа нэгэн үндэслэлгүйгээр ялгаатай үнэ /тариф тогтоохыг хориглоно
4	Канад	Өрсөлдөөний тухай хууль 1985 он	45, 46, 48-р заалтад хоёр буюу түүнээс дээш этгээд хэлцэн тохиролцож өрсөлдөөнийг хууль бусаар хязгаарлах, үндэслэлгүйгээр бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэх зэргийг хориглосон.	2009 он үнийн хялбарлалтай холбоотой заалтыг хүчингүй болгосон.
5	ИБУИНВУ	Өрсөлдөөний тухай хууль 1998 он	<p>2-р зүйлд заасны дагуу ИБУИНВУ дахь худалдаанд нөлөө үзүүлэх, ИБУИНВУ дахь өрсөлдөөнд харшлах, хязгаарлах, эсхүл гажуудуулах зорилго, үр дүн бүхий дараах гэрээ, хэлцэл, шийдвэр, үйл ажиллагаа зэргийг хориглоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- шууд болон шууд бусаар худалдах болон худалдан авах үнийг тогтоох, эсхүл худалдааны бусад нөхцөлүүдийг тогтоох;</li> <li>- Үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээл, техникийн дэвшил эсхүл хөрөнгө оруулалтыг хязгаарлах, эсхүл хянах;</li> <li>- Зах зээл, эсхүл нийлүүлэлтийн эх үүсвэрийг хуваах;</li> <li>- Харилцагч талуудад харилцан адил биш ялгавартай нөхцөл бүрдүүлэх;</li> <li>- Бусад талуудтай гэрээ хэлцэл хийхдээ, гэрээнд хамаарахгүй нөхцөл шаардах зэрэг болно.</li> </ul>	<p>18.2-т заасны дагуу давамгайл байдлаар аж ахуйн нэгж дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Шууд болон шууд бусаар шударга бус худалдах болон худалдан авах үнэ тогтоох, эсхүл бусад шударга бус худалдааны нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>- Хэрэглэгчдэд хохирол учруулахуйц хэмжээнд үйлдвэрлэлийн хэмжээ, зах зээл болон техникийн дэвшлийг хязгаарлах;</li> <li>- Харилцагч талуудад харилцан адил биш ялгавартай нөхцөл бүрдүүлэх;</li> <li>- Бусад талуудтай гэрээ хэлцэл хийхдээ, гэрээнд хамаарахгүй нөхцөл шаардах зэрэг болно.</li> </ul>